

## **“ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ НЭГДСЭН БҮРТГЭЛИЙН САН” СИСТЕМ АШИГЛАХ НӨХЦӨЛ**

### **Товч танилцуулга**

“Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэлийн сан” (цаашид систем гэх) нь эмнэлгийн мэргэжилтний лиценз, шалгалт, мэргэжлийн зэрэг, төгсөлтийн дараах сургалт болон ажилтны бусад хөгжлийн үйл ажиллагааг цахим хэлбэрт оруулан мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх зорилготой.

Систем нь дараах зорилтуудыг хангахад чиглэнэ. Үүнд:

- Эмнэлгийн мэргэжилтний үндсэн мэдээлэл, боловсрол, хөгжлийн мэдээллийн нэгдсэн сан үүсгэх
- Мэргэжлийн байгууллагаас хэрэгжүүлж буй сургалт хөгжлийн арга хэмжээний нэгдсэн бүртгэл, мэдээлэл бий болгох
- Эмч, мэргэжилтнүүдийн шилжилт, хөдөлгөөн
- Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, зуучлалын нэгдсэн бүртгэл
- Мэргэжлийн байгууллагуудын уялдаа холбоо
- Эмнэлгийн ажилтны харилцаа холбооны платформ
- Бодит цаг хугацаанд суурилсан эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, төгсөлтийн дараах /үндсэн, төрөлжсөн, мэргэжил дээшлүүлэх, багц цаг/ сургалт, шалгалт, мэргэжлийн зэрэг болон бусад үйл ажиллагааны баталгаажилт
- ЭМХТ-ийн эрхлэх чиг үүргийн дагуу бусад чиглэлээр нэгдсэн платформ бий болгох

Систем нь эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн бүрдэл, дүн шинжилгээ, судалгаа, тооцоо, төлөвлөлт хийх, мэдээ тайлан, лавлагаа гаргах, үйл ажиллагааны зохицуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, цаг хугацаа, төсөв санхүү хэмнэх чухал ач холбогдолтой.

Систем нь интернетийн холболтоор дамжуулан веб хөтөчөөр хандан орохоос гадна, гар утас, таблетыг хэрэглэгээг дэмжин ажиллана. Системд хандан орохын өмнө уг үйлчилгээний нөхцөлтэй танилцан зөвшөөрсөнөөр сайтын хэрэглэх нөхцөл, шаардлагыг хүлээн зөвшөөрч байгааг илэрхийлэх бөгөөд түүнтэй холбогдох бусад дагалдах нөхцлүүдийг хүлээн зөвшөөрч байгааг баталгаажуулна.

Монгол Улсын хуулийн хүрээнд боловсруулагдсан энэхүү хэрэглэх нөхцөл, шаардлагыг зөвшөөрснөөр та манай системийг ашиглах эрхтэй болно. Эрүүл мэндийн хөгжлийн төв нь энэхүү хэрэглэх нөхцөл, шаардлагыг цаашид урьдчилан мэдэгдэлгүйгээр өөрчлөх, тодотгох, нэмэлт оруулах, хэсэгчлэн устгах эрхтэй. Эдгээр өөрчлөлтүүдийг хийхдээ нөхцөл, шаардлагадаа өөрчлөлт оруулах бөгөөд бүртгэгдсэн хэрэглэгчиддээ гарсан өөрчлөлтийг мэдэгдэх болно.

Хэрэв системийн өөрчлөлт, шинэчлэлийг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд тус системийг хэрэглэхгүй байх эрхтэй. Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс оруулсан өөрчлөлт, шинэчлэлтийн дараа үргэлжлүүлэн хэрэглэж байгаа үйлдэл нь систем ашиглахыг хүлээн зөвшөөрсөн болохыг илтгэж байгаа бөгөөд та өөрчлөлт, шинэчлэлийн дагуу системийг ашиглаж болно.

## **Эрх нээлгэх болзол болон бүртгэл**

Системийн хэрэглэгч нь эрүүл мэндийн салбарт холбогдолтой ажил, албан тушаал эрхэлдэг байх ёстой бөгөөд мөн болохоо эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулж, хэрэглэх нөхцөл, шаардлагыг хүлээн зөвшөөрч, дагаж мөрдөх үүрэг хүлээнэ.

Системийн хэрэглэгч болохын тулд үнэн зөв, бодитой, бүрэн дүүрэн мэдээллийг бүртгүүлэх ба энэхүү мэдээллийнхээ үнэн зөв, бодит байдлын хариуцлагыг хүлээнэ. Бүртгэлийн нэг хэсэг болгон хэрэглэгчийн нэр, нууц үгээ баталгаажуулах асуултанд хариулах бөгөөд энэхүү сонгосон нэрийн доорхи бүхий л үйл ажиллагаанд хариуцлага хүлээж, нууц дугаараа чанд хадгалах үүрэгтэй. Хэрэглэгчийн нэр нь хэн нэгнийг дуурайсан, зохиогчийн эрхээр хамгаалагдсан болон бусад хуулинд харшлахаар эсвэл бүдүүлэг, бусдыг доромжилсон, зохисгүй үг хэллэг агуулсан тохиолдолд нэрийг хэрэглэгчид олгохоос татгалзах бүрэн эрхтэй.

Системд хандах эрх, нууц үгийг и-мэйлээр сэргээх тохиргоотой тул ашигладаг и-мэйл хаяг оруулах шаардлагатай.

## **Хэрэглэгчийн үйл ажиллагаа болон тохиромжтой контент**

Системийг аливаа хууль бус болон эрх олгогдоогүй үйлдэлд ашиглах эрхгүй. Гадаадын болон олон улсын хэрэглэгчид дотоодын хууль, дүрэм, журмыг даган мөрдөнө. Систем дээр хэрэглэгчийн хийсэн үйлдэл, нийтлэсэн, хүлээлгэн өгсөн аливаа текст, мэдээлэл, тоо баримт, график, гэрэл зураг, аудио, видео клип, кино, линк болон бусад контентийн (бүхэлд нь материал) зохиогчийн эрхийн болон бусад хариуцлагыг контент оруулсан хэрэглэгч (Publisher user) өөрөө хүлээнэ.

Хууль бус, хуулбарласан, айлган сүрдүүлсэн, эзэн биегүй, бусдын гутаан доромжилсон, бусад этгээдийн оюуны өмчинд халдсан болон энэхүү хэрэглэх нөхцөл, шаардлагыг зөрчсөн системийн хэрэглэгчдийн (Publisher user) оруулсан материалыг устгах, хязгаарлах болно. Өөрөөр хэлбэл систем нь (Publisher user) хэрэглэгчдийн оруулж буй аливаа контент, материалын зохиогчийн эрхийг зөрчсөн тохиолдолд хязгаарлалт хийх үүрэгтэй.

180 хоногоос дээш хугацаанд идэвхгүй байсан хэрэглэгчийн нэр, дансыг идэвхгүйжүүлэх эрхтэй.

## **Хэрэглэх нөхцөл**

Хэрэглэгчийн нэр дээр хийсэн бүх төрлийн үйлдлийг систем ашиглалтын (log) файл болгон хадгалагдах бөгөөд хууль бус, ёс зүйгүй үйлдлийн хариуцлагыг хэрэглэгч бүрэн хариуцана.

Олон улсын болон Монгол Улсын хууль, тогтоомж, дүрэм, журмыг дагаж мөрдөх шаардлагатай. Жишээлбэл, дараах үйлдлүүдийг (зөвхөн үүгээр хязгаарлагдахгүйгээр) хийхгүй байхыг хэрэглэгч хүлээн зөвшөөрч байгаагаа баталгаажуулсанд тооцно. Үүнд:

- Бусдыг доромжлох, буруугаар ашиглах, ичээх, айлган сүрдүүлэх, бусдын хувийн нууцад халдах.
- Бусдын мэдээллийн албан бус байдлаар ашиглах, бусдад дамжуулах.
- Мэдээллээ санаатайгаар буруу оруулж, баталгаажуулахгүйгээр ашиглахыг оролдох, бусдыг төөрөгдүүлэх.

- Эрх бүхий албан хаагчид эрүүл мэндийн ажилтны буруу мэдээллийг хариуцлаггүйгээр болон санаатайгаар баталгаажуулах.
- Аливаа хортой, хохирол учруулахуйц, бусдыг үзэн ядсан, арьс өнгө, яс үндэс, шашин шүтлэгээр нь үзэн ядсан, үгүйсгэсэн, ялгаварласан, материал, мэдээллийг нийтлэх, тараах.
- Бусад гишүүдийн талархан хүлээн авсан урилгын дагуу олж авсан хувийн мэдээллийг хэлхээ, холбоо тогтоохоос бусад зорилгоор ашиглахгүй байх.
- Хууль бус эсвэл бусдын эрхийг зөрчих үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих, сурталчлах материал нийтлэх.
- Системийн ажилтны нэрийг хуурамчаар болон төөрөгдүүлэх замаар үүсгэх, бий болгон бусдыг залилах, бусдыг мэхлэн мэдээлэл олж авах, материал тараах, түгээх, олж авах,
- Харилцаа холбооны хэрэгслийн эд анги болон програм хангамжийг зогсоох, саатуулах, устгах хязгаарлах (хязгаарлагдахгүйгээр) саад учруулах файл, програм агуулсан Trojan horse, worm, time bombs, cancel-bots, компьютерийн код агуулсан програм хангамжийн вирус бүхий материалыг дамжуулах, и-мэйлээр илгээх, нийтлэх
- Системийн үйлчилгээг аливаа хууль бус зорилгоор ашиглах, эсвэл системд хохирол учруулах, ажилгүй болгох, ачааллыг зохиомлоор нэмэгдүүлэх.
- Нууц үгийг ухах болон бусад замаар системийн үйлчилгээ, бусад данс компьютерийн систем, сүлжээнд зөвшөөрөлгүйгээр нэвтрэх эдгээр бүгд орно.

ЭМХТ 2021 он